ГАН ХИЙЦ ХК

# ГАН ХИЙЦ ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

С.Баяртогтох
Гүйцэтгэх захирал

2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр

# ГАН ХИЙЦ ХК ТАНИЛЦУУЛГА

Манай компани нь 1985 онд жилдээ 6000 тн төрөл бүрийн төмөр хийц эдлэл үйлдвэрлэх хүчин чадалтайгаар “**Барилгын Материалын Үйлдвэрийн Яам-**”ны харъяа Барилгын Төмөр Хийцийн Үйлдвэр нэртэйгээр анх үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 1992 оноос үйлдвэрлэл худалдааны “Ган хийц” хувьцаат компани болон өөрчлөгдөн зохион байгуулагдсан.

Манай компани ***“Иргэний ба үйлдвэрийн барилгын даацын болон даацын бус бүх төрлийн төмөр хийц, халаалтын тогоо, даралтат эд анги, цахилгаан станцын технологийн төмөр хийц, төрөл бүрийн ахуйн зориулалттай төмөр хийц***” зэргийг голлон үйлдвэрлэж байна.







# 2018 ОНЫ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУД

| Захиалагч | Ажлын нэр | Хаана хийсэн | Гэрээ байгуулсан хүний нэр | Үнэ /мян.төг/ |
|---|---|---|---|---|
| **Ган эрдэнэ констракшн ХХК** | 22х23х10-11м 7х14х5-5,5м төмөр хийц | СХД, 7 хороо | Захирал М.Батзориг /88060852/ | 174 240,0 |
| **“Жи Си Ар монголиа” ХХК** | Сэндвичэн барилгын төмөр хийц угсрах | Хан уул дүүрэг 15 хороо шинэ мянганы барилга 5 давхар | Гүйцэтгэх Захирал Б.Жонон / 70119797/ | 75 648,9 |
| **Дорнод аймаг** | Конторын барилга | Чойболсон хот | Засаг даргын тамгын газар | 743 537,7 |
| **Ай Си нэт ХХК** | 15 м өндөртэй дөрвөлжин цамхагний төмөр хийц | Улаанбаатар хот | Захирал Б.Алтантуяа 88026040 | 10 598,5 |
| **Шинэ хонгор ХХК** | Төмөр хийц үйлдвэрлэх угсрах | СБДүүрэг 2-р хороо | Төслийн удирдагч Ц.Өлзий-орших | 132 400,4 |
| **Мак Цемен ХХК** | Үйлдвэрийн өргөтгөл | Дорноговь Даланжаргалан сум | Гүйцэтгэх захирал Б.Баттулга | 191 727,2 |

# ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БАРИЛГА УГСРАЛТ



- Хариуцсан инженер: **Барилга угсралт хариуцсан захирал Ц.Пүрэвжаргал**



# ГАН-ЭРДЭНЭ КОНСТРАКШН ХХК-ИЙН ЗАХИАЛГААР ТӨМӨР ХИЙЦ ҮЙЛДВЭРЛЭЛ







# МОНГОЛ АЛТ КОМПАНИЙН ҮЙЛДВЭРИЙН ӨРГӨТГӨЛИЙН ТӨМӨР ХИЙЦ, УГСРАЛТ



- Хариуцсан инженер: Барилгын инженер **Ц.Пүрэвжаргал**



# ШИНЭ ХОНГОР ХХК-ИЙН ЗАХИАЛГААР ТӨМӨР ХИЙЦ ҮЙЛДВЭРЛЭЛТ, УГСРАЛТ



- Хариуцсан инженер: Ерөнхий инженер **Б.Ганбат**



# ХҮНИЙ НӨӨЦ ОРОН ТОО , БҮТЭЦ

Ган хийц ХК нь 27 ажлын байранд 2019 оны 04 дүгээр сарын байдлаар нийт 33 ажилтан ажиллаж байна.

Үүнээс :

- Захиргаа аж ахуй -10
- Инженер техникийн алба-7
- Засвар үйлчилгээний хэсэг -7
- Үйлдвэрлэлийн цех -9

Үүнээс: Эрэгтэй -25

Эмэгтэй -8

Ажилласан жилээр харуулбал:

- 0-1 жил 10 хүн
- 1-5 жил 4 хүн
- 6-10 жил 8 хүн
- 10-15 жил 3 хүн
- 15 дээш жил 8 хүн тус тус ажиллаж байна.

# ОРОН ТОО, БҮТЭЦ

- 2018 онд оролт гаралтын тоог харьцуулахад :

  Ажилд орж байгаа хүмүүс 21 хүн

  Ажлаас гарч байгаа хүмүүс 26 хүн байна.
- Ажлаас гарах болсон шалтгаан нь өөрийн хүсэлтээр гарч байгаа боловч, ярилцлага хийж үзэхэд цалин хугацаандаа олгохгүй байх, өвлийн улиралд сул зогсолттой гэсэн шалтгаанаар ажилласан гарч байна.

# СУРГАЛТ

2018 онд сургалтын төлөвлөгөө боловсруулан ажилласан.

Үүнээс:

1. **Гамшигийн сургалт**
2. **Иргэний хамгаалалтын сургалт**
3. **Үйлдвэрчний эвлэлийн сургалт**
4. **Мэргэшсэн архитеторын сургалт**

гэсэн 4 сургалтад суусан байна. Манай компанийн хувьд олон жил тогтвор суурьшилтай ажилласан ажилчдын мэргэжилийг дээшлүүлэх, давтан сургалтанд тогтмол хамруулж байх шаардлага тулгараад байна.

2018 оны сургалтын төлөвлөгөө

| № | | Сургалтын нэр | Хамрагдах хүмүүс | Хугацаа | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | Дотоодын сургалт, мэдээлэл | | | |
| 1 | Дотоодын сургалт | Нийт ажилчдыг мэдээлэл өгөх | Нийт ажилтан | 4 сард | Хүний нөөц, санхүү, ХАБЭА |
| 2 | Дотоодын сургалт | Харуул хамгаалалтын сургалт | Харуулууд, цехийн мастерууд | 4 сард | Хүний нөөцийн менежер |
| 3 | Дотоодын сургалт | Инженер техникийн албаны сургалт | | | Үйлдвэрлэл хариуцсан захирал |
| 4 | Дотоодын сургалт | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт | Нийт ажилтан | сар бүр | ХАБЭА инженер |
| 5 | Дотоодын сургалт | Гагнуурчин, төмөр хийцийн угсрагч | | улирал | Үйлдвэрлэлийн менежер |
| | | Богино хугацааны сургалт | | | |
| 1 | Гадны байгууллагаас авах сургалт | Анханы тусламжийн нөхөрлөлийн баг сургалт | | | Улаан загалмайн нийгэмлэг |
| | Гадны байгууллагаас авах сургалт | Гамшигаас хамгаалах сургалт | | | |
| 2 | Гадны байгууллагаас авах сургалт | Галын аюулгүй байдлын сургалт | | | Онцгой байдал |
| 3 | Гадны байгууллагаас авах сургалт | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт | | | |
| 4 | Гадны байгууллагаас авах сургалт | | | | |
| 5 | Гадны байгууллагаас авах сургалт | Захирлуудын сургалт | | | |
| | | Мэргэжлийн чиглэлийн сургалт | | | |
| 1 | Гадны байгууллагаас авах сургалт | Нягтлан бодох бүртгэл | Санхүүгийн алба | | Болор-эрдэнэ |
| 2 | Гадны байгууллагаас авах сургалт | Зургийн мэргэшсэн инженерийн сургалт | | | Батхишиг, Амартүвшин |
| 3 | Гадны байгууллагаас авах сургалт | Материал технологийн мэргэжилийн зэрэг олгох сургалт | | | Б.Нямдаваа |
| 4 | Гадны байгууллагаас авах сургалт | Гагнуурчдын мэргэжил дээшлүүлэх сургалт | | | гагнуурчид |
| 5 | Гадны байгууллагаас авах сургалт | Осорлогч дохиочин сургалт | | | |

# ШАГНАЛ ТЭТГЭМЖ

- Компанийн өндөр настан ахмадуудыг жил бүр хүлээн авч хүндэтгэл үзүүлж байна.
- Шинэ жилийн баяр болон Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан компанийн ажилчдын хүүхдүүдэд гарын бэлэг гардуулсан.
- Барилгын салбар үүсч хөгжсөний 92 жилийн ойг тохиолдуулан компанийн ажилчдыг амралтад амраасан.
- Мөн ажилчдын ар гэрийн гачигдал, гэр бүл болсон, шагнал урамшуулал, тэтгэмж зэрэгтэй холбоотой тусламж дэмжлэгийг Компанийн “Шагнал тэтгэмжийн дүрэм”-ийн дагуу олгож байна.

# ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

- Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр жил бүр төлөвлөгөө гаргаж, төсөвт 10 000 000 төгрөг тусгасан боловч, хөрөнгө мөнгөний асуудлаас болж төлөвлөгөөний дагуу ажил хийгдээгүй байна.
- Цехийн ажилчид, харуул жижүүрийн ажлын хувцас, гутлын эдэлгээний хугацаа дууссан. Шинээр хангалт хийгдэх хугацаа хэтэрсэн.
- Ажилчид сүүлийн 3 жил эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй. Үүнээс болж 2018 онд Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын албанаас шалгалт хийж 750 000 төгрөгийн торгууль тавигдсан байна.
- Хор саармагжуулах бүтээгдэхүүн сүүлийн жилүүдэд олгогдоогүй.
- Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх шаардлагатай бөгөөд үүнд гэрэлтүүлэг, агааржуулалт, тоосжилт, гагнуурын утааны хор хэмжээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж тодорхойлуулдаг.

# САНХҮҮ

“Ган хийц” ХК-н 2018 оны жилийн эцсийн Санхүүгийн тайланг 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тайлант жилийн борлуулалтын орлого 1,14 тэрбум төгрөг,борлуулсан бүтээгдэхүүний өртөг 650,5 сая төгрөг болон тус тус өсч нийт ашиг 495,3 сая төгрөг болсон. Ерөнхий ба удирдлагын зардал 469,8 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардал 3,3 сая төгрөг болж Татвар төлөхийн өмнөх ашиг нь 22,5 сая төгрөгийн ашигтай гарч 2,25 сая төгрөгийн орлогын татвар төлөлттэй гарч 20,3 сая төгрөгийн тайлант үеийн цэвэр ашигтай гарсан.

# САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2018 оны 1-р сарын 1 | 2018 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 30 038 173.04 | 47 210 818.48 |
| 2 | Дансны авлага | 1 449 548  547.24 | 1 371 662 948.64 |
| 3 | Бараа материал | 123 746 663.81 | 296 529 151.29 |
| 4 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 1 580 848 237.79 | 1 665 939 326.08 |
| 5 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **3  184 181 621.87** | **3 226 342 244.5** |
| 6 | Үндсэн хөрөнгө | 1 400 233 788.04 | 1 399 120 585.77 |
| 7 | Урт хугацаат  хөрөнгө оруулалт | 323 132 612.61 | 323 132 612.61 |
| 8 | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **1 723 366 400.66** | **1 722 253 198.39** |
| 9 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **4 907 548 022.54** | **4 948 595 442.89** |

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2018 оны 1-р сарын 1 | 2018 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | Дансны өглөг | 308 821 580.53 | 350 016 090.81 |
| 2 | Цалингийн өглөг | 5 548 557.10 | 27 478 104.70 |
| 3 | Татварын өр | 170 556 782.57 | 234 507 848.49 |
| 4 | НДШ - ийн өглөг | 20 112 640.88 | 47 604 380.94 |
| 5 | Богино хугацаат зээл | 1 445 411 400.00 | 1 295 410 421.14 |
| 6 | Урьдчилж орсон орлого | 2 154 514 000.97 | 2 191 265 354.21 |
| 7 | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **4 104 964 962.07** | **4 146 282 200.30** |
| 8 | **Эздийн өмч** | 24 246 400.00 | 24 246 400.00 |
| 9 | Эздийн өмчийн бусад хэсэг | 798 700 593.97 | 798 700 593.97 |
| 10 | Хуримтлагдсан ашиг | -20 363 933.49 | -20 633 751.37 |
| 11 | **Эздийн өмчийн дүн** | **802 583 060.48** | **323 232 879.36** |
| 12 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **4 907 548 022.54** | **4 948 595 442.90** |

# ОРЛОГЫН ТАЙЛАН

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2018 оны 1-р сарын 1 | 2018 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **1 973 121 091.62** | **1 145 833 559.45** |
| 2 | Борлуулалтын өртөг | 1 392 809 852.49 | 650 555 947.27 |
| **3** | **Нийт ашиг ( алдагдал)** | **580 311 239.13** | **495 277 612.18** |
| 4 | Түрээсийн орлого | 12 000 000.00 | |
| 5 | Хүүний орлого | 120 277.75 | 373 388.73 |
| 6 | Бусад орлого | | |
| 7 | Ерөнхий ба удирдлагын зардал | 551 375 941.87 | 469 804 364.56 |
| 8 | Бусад зардал | 3 825 768.46 | 3 285 034.00 |
| 9 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 209 239.52 | |
| 10 | **Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)** | **37 439 046.07** | **22 561 602.35** |
| 11 | Орлогын татварын зардал | 3 743 904.61 | 2 256 160.23 |
| 12 | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **33 695 141.46** | **20 305 442.12** |

# БАЛАНСЫН БҮТЦИЙН ШИНЖИЛГЭЭ

| БАЛАНСЫН ЗҮЙЛ | 2017он | Дүнд эзлэх % | 2018 он | Дүнд эзлэх % | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 30 038.2 | 0,6% | 47 210 | 0.9% | 17171,8 | |
| Авлага | 1 449 548.5 | 29,5% | 1 371 662,9 | 27,7% | (77885,6) | |
| Урьдчилж төлсөн зардал | 1 580 848,2 | 32,2% | 1 665 939,3 | 33,6% | 85 091,1 | |
| Бараа материал | 123 746,7 | 2,5% | 296 529,1 | 5,9% | 172 782,4 | |
| НИЙТ ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 3 184 181,6 | 64,9% | 3 226 342,2 | 65,1% | 42 160,6 | |
| Үндсэн хөрөнгө | 1 400 198.8 | 27,7% | 1 399 120,5 | 28,2% | (1 078.3) | |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 323 132.6 | 6,4% | 323 132.6 | 6,4% | - | |
| НИЙТ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ | 1 723 331.4 | 35,1% | 1 722 253,2 | 34,8% | (1 078.2) | |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 4 907 548,0 | 100.0% | 4 948 595,4 | 100% | 41 047.4 | |
| Дансны өглөг | 308 821.6 | 6,1% | 350 016,1 | 7,1% | 41 194.5 | |
| Цалингийн өглөг | 5 548.6 | 0,1% | 27 478,1 | 0,5% | 21 929.5 | |
| Татварын өглөг | 170 556,8 | 3.5% | 234 507,8 | 4,7% | 63 951 | |
| НДШ-н өглөг | 20 112.6 | 0.4% | 47 604,4 | 0,9% | 27 491.8 | |
| Богино хугацаат зээл | 1 445 411.4 | 29,5% | 1 295 410,4 | 26,1% | (150 001) | |
| Урьдчилж орсон орлого | 2 154 514,0 | 43,9% | 2 191 265,3 | 44,2% | (36 751.3) | |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР | 4 104 964,9 | 83,6% | 4 146 282,2 | 83,7% | 41 317.3 | |
| Эздийн өмч | 24 246.4 | | 24 246.4 | | - | |
| Хуримтлагдсан ашиг | -20 363,9 | | -20 633,7 | | 269.3 | |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 798 700.6 | | 798 700.6 | | - | |
| ЭЗНИЙ ӨМЧ | 802 583,1 | 16,4% | 323 232,8 | 6,5% | (479 350.3) | |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ | 4 907 548,0 | 100.00 % | 4 948 595,4 | 100% | 41 047.4 | |

Балансын бүтцийг авч үзвэл нийт цэвэр хөрөнгө 4 948.6 сая төгрөг болж, урьд оны мөн үетэй харьцуулахад 41.0 сая төгрөгөөр нэмэгджээ. Хөрөнгийн бүтцээр нь авч үзвэл; нийт эргэлтийн хөрөнгө 3 226.3сая төгрөгт хүрч, урьд оны мөн үетэй харьцуулахад 42160.6сая төгрөгөөр өссөн байна.

2017 оны гүйцэтгэлээр эзний өмч 16.4%-ийг эзэлж байсан бол тайлант онд 6.5% болж, өр төлбөрийн эзлэх хувийн жин 83.6% байснаа 83,7% болж өссөн байна.

Нийт өр төлбөрийн 44.2% нь тухайн онд хийж дуусаагүй ажлын урьдчилж орсон орлого, 26.1% банкны богино хугацаат зээл байна.

# ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Эргэлтийн хөрөнгө нийт дүнгээрээ 42,2 сая төгрөгөөр өсч, 3,226,3 сая төгрөгт хүрчээ.

Авлага нийт дүнгээрээ 77,9 сая төгрөгөөр хасагдаж, 1,371,6 сая төгрөгт хүрсэн. Авлагыг бүтцээр авч үзвэл:

Байгууллагаас авах авлага 1 368,7 сая төгрөг

Хувь хүмүүсээс авах авлага 3,3 сая төгрөгийг тус тус эзэлж байна.



# ӨР ТӨЛБӨР, ЭЗНИЙ ӨМЧ

- Нийт өр төлбөр дүнгээрээ 4,146,3 сая төгрөгт хүрч, урьд оны мөн үетэй харьцуулбал 42,0 сая төгрөгөөр өссөн байна.
- Үүнээс дансны өглөг 350,0сая төгрөг буюу 0,88%-р өссөн, татвар нийгмийн даатгалын өглөг 130,1 сая төгрөгөөр өссөн, мөн банкны богино хугацаат өглөг 2018 онд 150,0 сая, 2019 оны эхний байдлаар 290,9 сая төгрөгөөр багассан.



# ЗЭЭЛИЙН ТАЛААР

- 2014 онд төрөөс 2,5 тэрбум зээл авч, тэр ондоо сар бүр зуун сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийсэн ба нийтдээ 2014 онд зөвхөн хүү 104’060’620 төгрөг, зээлийн эргэн төлөлтөд 833’333’333 төгрөг төлсөн. 2015 онд зээлийн хүү төлөлт 113 937 507,59 төгрөг төлж, нийт зээлийн үлдэгдэл 1,4 тэрбум төгрөг болсон. 2016 онд зээлийн хүүнд 256 525 074,95 төгрөг үндсэн зээлийн төлөлт хийгдээгүй. 2017 онд зээлийн хүүнд 110,7 сая төгрөг төлсөн ба үндсэн зээлийн төлөлт хийгдээгүй. 2018 онд үндсэн зээлээс 150 сая төгрөг төлж барагдуулсан. 2019 оны 1 сард үндсэн зээлээс 33 412 500 төгрөг, 2 сард 257 516 500 төгрөгийг тус тус төлж, үндсэн зээл **1 004 481 421.14** болсон. Үүнээс үзэхэд манай компани 2014 оноос хойш өнөөдрийг хүртэл зээлийн хүүнд нийтдээ 585,2 сая төгрөг төлсөн байна.
- Хас банкнаас авсан зээлийн асуудал нь маргаантай байгаа ба шүүх эцэслэн шийдвэрлээгүй болно.

# ОРЛОГЫН ТАЙЛАН

- Тайлант оны борлуулалтын орлого нь үндсэн үйл ажиллагааны орлого 1,145,8 сая төгрөг мөн хүүний орлого 0,1 сая бүрдэж байна.
- 2017 оны мөн үеийн байдалтай харьцуулвал Борлуулалтын орлого 828,0 сая төгрөгийн бууралттай байна.

# КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

2018 онд "Ган хийц" ХК – ний төмөр хийцийн үйлдвэр нь захиалгат ажил багатай жил байлаа. 6,7 сард ажил байхгүйн улмаас ажилчдаа амраасан. 2018 оны борлуулалтын орлого нь 1145,8 тэрбум төгрөг, захиалгат ажлуудын нийт төмөр хийцийн жин 150 тонн үйлдвэрлэсэн байна.

| Он | Төмөр хийцийн жин /тонн/ | Борлуулалтын орлого /сая.төг/ |
|---|---|---|
| 2016 | 215.13 | 1714.4 |
| 2017 | 240 | 1626 |
| 2018 | 150 | 1145.8 |



# 2018 ОНД УЛСАД ТӨЛСӨН ТАТВАР

| № | Татвар | 2016 он | 2017 он | 2018 он |
|---|---|---|---|---|
| 1 | НДШ | 82 093 744.94 | 67 000 000 | 44 800 000 |
| 2 | НӨАТ | 171 445 198 | 100 000 | 5 000 000 |
| 3 | ХАОАТ | 27 857 068.07 | 26 000 000 | 29 028 750 |
| 4 | Үл хөдлөх | 5 792 980 | 5 791 980 | 5 792 980 |
| 5 | Тээврийн хэрэгсэл | 1 030 800 | 1 035 200 | 230 000 |
| 6 | Газрын татвар | 2 370 192 | 2 150 192 | 1 295 396 |
| Дүн | | 290 589 983,01 | 102 077 372 | 86 147 126 |

# ТУЗ-ИЙН БОЛОН ЗАА-Н 2018 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

| № | | Төсөв | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | Захиргаа , үйлчилгээний хэсгийн орон тоо, цалингийн сан | 551 719 560 | 386 043 982 | 165 675 578 |
| 2 | Төлөөлөн удирдах зөвлөлийн цалингийн сан | 118 752 000 | 87 045 417 | 21 706 583 |

Хавсралтаар төсвийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүйг харуулав.



# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ СЭНГЭЭ ОВОГТОЙ БАЯРТОГТОХ

2018 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр Сэнгээ овогтой Баяртогтох миний бие Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр гурван сарын хугацаатай томилогдож, 2018 оны 12-р сарын 06-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар Ган хийц ХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна. Ажиллах хугацаандаа дараах тулгамдсан асуудлууд байгааг мэдэж, үүнийхээ дагуу хэд хэдэн ажил зохион байгуулахаар ажиллаж байна.

Төмөр хийцийн үйлдвэрийн өнөөгийн байдал

1. Үйлдвэрийн барилга байгууламж
2. Үйлдвэрийн тоног  төхөөрөмж, машин механизм
3. Үйлдвэрийн инженер техникийн ажилчид
4. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа
5. Ажиллах хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил

# 1. ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

- Үйлдвэр болон албан конторын барилгын дээвэр муудсан.
- Үйлдвэрийн хаалга, цонх, агааржуулалт, гэрэлтүүлэг, халаалт хуучирч шаардлага хангахгүй.
- Үйлдвэрийн дотор замбараагүй хог хаягдал их
- Инженерийн шугам сүлжээнүүд муудсан
- Гадна тохижилт, талбайн зохион байгуулалт төлөвлөлтийг шинээр хийх шаардлагатай.

# Үйлдвэр болон албан конторын барилгын дээвэр муудсан







- Үйлдвэрийн хаалга, цонх, агааржуулалт, гэрэлтүүлэг, халаалт хуучирч шаардлага хангахгүй.
- Үйлдвэрийн дотор замбараагүй хог хаягдал их










R

R








# ҮЙЛДВЭРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, МАШИН МЕХАНИЗМ

- Үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд муудаж хуучирсан
- Машин техникийн зарим эд анги муудсан, дугуй элэгдэж нимгэрсэн
- Үйлдвэрийн дотор өргөгч краны ажиллагаа муу
- Ажлын багаж эвдэрч ажиллагаагүй болсон, хүрэлцэхгүй























# 2018 ОНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

# ТУЗ, ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

- Ган хийц ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.
- Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй бөгөөд ердийн гишүүд 6, хараат бус гишүүд 3-тай ажиллаж байна.
- Аудит, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороод ажилладаг.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь хуралдаа тогтмол оролцож, санал хүсэлтээ илэрхийлж ажилласан.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 21 тогтоол шийдвэр гарсан бөгөөд үүнээс 4 тогтоол нь ТУЗ-ийн гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Үүнд:
  - Ногдол ашиг тараах шийдвэр II/19
  - Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай II/25
  - Гүйцэтгэх захирлыг томилох тухай  XII/06
  - Зөвшөөрөл олгох тухай  V/31

# НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ ШИЙДВЭР

- 2018 онд 09 дүгээр сарын 21-ны өдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 98 хувьцаа эзэмшигчийн 1 264 500 төгрөгийг дансанд байршуулсан.
- Дараах хувьцаа эзэмшигчид ногдол ашгийн өглөгтэй байна.
  - М.Даваасүрэн
  - Хасвуу ХХК
- 2019 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Нэгж хувьцаанд 50 төгрөг хуваарилахаар шийдвэрлэсэн.


ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДААНЫ
"ГАН ХИЙЦ"
ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 оны 2- сарын 19-ны өдөр № 23 Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 02-р сарын 19-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. 2018 оны үйл ажиллагааны үр дүнгээр ногдол ашгийг нэгж хувьцаанд 50 төгрөгөөр тогтоож, холбогдох Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан олгохыг ТУЗ-ийн дарга /М.Даваасүрэн/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА М.ДАВААСҮРЭН
ТУЗ-ИЙН ГИШҮҮД Ц.ЖАНЛАВ
Э.ДОЛГОРСҮРЭН
Д.НЯМЖАВ
Д.ЭНХБААТАР
Б.ЭРДЭНЭБАЯР
Ц.ПҮРЭВЖАРГАЛ
Б.ГАНБАТ
Д.ОЮУНЗУЛ

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2017-2019 ОНЫ БҮРЭЛДЭХҮҮН



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

| № | Энгийн хувьцаа эзэмшигчид | Хувьцааны тоо /нийт 242464 ширхэг/ | Нийт хувьцаанд эзлэх хувь /%/ |
|---|---|---|---|
| 1 | М.Даваасүрэн | 173 580 | 71.59 |
| 2 | Хасвуу ХХК | 44263 | 18.25 |
| 3 | Бусад /119 хувьцаа эзэмшигч/ | 24621 | 10.16 |

Манай компанийн хувьцаа нь 26 брокерын компаниудад 242464 ширхэг хувьцаа байршдаг бөгөөд хамгийн их хувьцаа нь Дэлгэрхангай секюритис, Би ди сек брокерийн компаниудад байршсан байна.

# ЦААШИД АНХААРЧ АЖИЛЛАХ АЖЛУУД БА ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖИЛ

1. 2018 онд түүхий эд материал бэлтгэлийг БНХАУ – аас татан авч байгаа бөгөөд 2019 онд мөн БНХАУ-аас өөрсдөө татан авалт хийхээр төлөвлөж байна.
2. Компанийн өр авлагыг цэгцэлсний дараа зарлагдаж байгаа тендер, сонгон шалгаруулалтад тогтмол оролцож байх
3. Захиргаа аж ахуйн болон инженер техникийн албаны хүмүүсийг үе шаттайгаар мэргэшүүлэх сургалтад суулгаж мэргэшүүлнэ. Мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн зэргийг дээшлүүлэх сургалтад хамруулна.
4. Япон улсад барилгын салбарт гэрээний дагуу ажилчдыг үе шаттайгаар ажиллуулж байна. Эхний ээлжийн хүмүүс 1 сард яваад 4 сард ирсэн.
5. Инженерүүд болон үйлдвэрийн ажилчдад ажлын зуны хувцасны хангалтыг өгөхөөр төсөвлөөд байна.
6. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулахаар төлөвлөсөн.
7. Гэрээгээр ажиллаж байгаа бригад болон хувь хүмүүсийг хариуцлагыг өндөржүүлэх, гэрээ дүгнэсэн актыг сайжруулах
8. Компанийн дотоод журмыг чанад мөрдүүлж ажиллах тал дээр анхаарч ажиллана.
9. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг цаг тухай бүрт нь тогтмол олгоно.
10. Ажилчдыг сул зогсолтын үед Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулна.

- 2018 онд үйлдвэрийн хуучин тоног төхөөрөмжөөрөө өөрсдийн нөөц боломжоороо арчилж, тордож 150 тонн төмөр хийц үйлдвэрлэжээ. Цаашдаа тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг маш яаралтай хийх шаардлагатай байна.

2019 онд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх талаар доорх компанитай хамтарч ажиллахаар санал өгсөн.

**Ferrostaal** гэж германы 1 номерын үйлдвэр нь үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин техник үйлдввэрлэж нийлүүлдэг, төсөл санхүүжүүлдэг, тоног төхөөрөмжийн зээл гаргадаг.

**Ferrostaal Mongolia co.ltd** нь манай компанийг албан ёсоор танилцуулж түнш, хамтрагч, санхүүжүүлэгчтэй холбож өгөх боломжтой гэдгийг мэдэгдсэн.

- Үйлдвэрийн цахилгааны шугам сүлжээг бүрэн шинчлэх/ Уг засварт 52 506 100 төгрөгийн төсвийн тооцоо гарсан./









| д/д | Материалын нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Кг кабель 4*240 | М | 95 | 240.000 | 22.800.000 |
| 2 | Кг кабель 4*150 | М | 55 | 150.000 | 8.250.000 |
| 3 | Кг кабель 4*70 | М | 85 | 75.000 | 6.375.000 |
| 4 | Кг кабель 4*50 | М | 149 | 50.000 | 7.450.000 |
| 5 | Кг кабель 4*16 | М | 180 | 17.500 | 3.150.000 |
| 6 | Кг кабель 4*10 | М | | 12.500 | |
| 7 | Кг кабель 4*6 | М | | 7.200 | |
| 8 | Кг кабель 4*4 | М | | 5.500 | |
| 9 | Кг кабель 4*2.5 | М | | 3.200 | |
| 10 | Кг кабель 2*10 | М | | 7.500 | |
| 11 | Кг кабель 2*6 | М | | 4.300 | |
| 12 | Кг кабель 2*4 | М | | 3.200 | |
| 13 | Кг кабель 2*2.5 | М | | 2.900 | |
| 14 | 3 фаз 1000А автомат | Ш | | 950.000 | |
| 15 | 3 фаз 800А автомат | Ш | 1 | 680.000 | 680.000 |
| 16 | 3 фаз 630А автомат | Ш | 1 | 315.000 | 315.000 |
| 17 | 3 фаз 400А автомат | Ш | 3 | 295.000 | 885.000 |
| 18 | 3 фаз 250А автомат | Ш | 3 | 280.000 | 840.000 |
| 19 | 3 фаз 160А автомат | Ш | 3 | 150.000 | 450.000 |
| 20 | 3 фаз 100А автомат | Ш | | 23.000 | |
| 21 | 3 фаз 63А автомат | Ш | | 18.000 | |
| 22 | 3 фаз 50А автомат | Ш | | 18.000 | |
| 23 | 3 фаз 40А автомат | Ш | | 8.500 | |
| 24 | 3 фаз 32А автомат | Ш | | 8.500 | |
| 25 | 3 фаз 25А автомат | Ш | | 8.500 | |
| 26 | 3 фаз 16А автомат | Ш | | 8.500 | |
| 27 | 2 фаз 50А автомат | Ш | | 5.500 | |
| 28 | 2 фаз 40А автомат | Ш | | 5.500 | |
| 29 | 2 фаз 32А автомат | Ш | | 5.500 | |
| 30 | 2 фаз 25А автомат | Ш | | 5.500 | |
| 31 | 2 фаз 16А автомат | Ш | | 5.500 | |
| 32 | 2 фаз 10А автомат | Ш | | 5.500 | |
| 33 | Төгсгөвч зэс ф 240 | Ш | 6 | 7.500 | 45.000 |
| 34 | Төгсгөвч зэс ф 150 | Ш | 8 | 6.500 | 52.000 |
| 35 | Төгсгөвч зэс ф 70 | Ш | 8 | 2.500 | 20.000 |
| 36 | Төгсгөвч зэс ф 50 | Ш | 20 | 2.000 | 40.000 |
| 37 | Төгсгөвч зэс ф 16 | Ш | 24 | 900 | 21.600 |
| 38 | Төгсгөвч зэс ф 10 | Ш | 6 | 800 | 4.800 |
| 39 | Төгсгөвч зэс ф 6 | Ш | 6 | 450 | 2.700 |
| 40 | Төгсгөвч зэс ф 4 | Ш | | 450 | |
| 41 | Төгсгөвч зэс ф 2.5 | Ш | | 100 | |
| 42 | 100*80 хайрцаг | Ш | 1 | 165.000 | 165.000 |
| 43 | 80*60 хайрцаг | Ш | 8 | 120.000 | 960.000 |
| 44 | 50*40 хайрцаг | Ш | | 48.000 | |
| 45 | 3 фаз тэжээлийн шин | М | | 20.000 | |
| 46 | Автоматын зам | М | | 2.000 | |
| 45 | Бүгд үнэ | | | | 52,506,1000 |

Хянсан. Засварын хэсгийн дарга М. Батцэнгэл..............

Тооцоо хийсэн цахилгаанчин Х. Бэх..............

# ҮЙЛДВЭРТ ШИНЧЛЭЛ ХИЙХ АЖИЛ

Үйлдвэрийн дээврийн засах асуудлаар Технониколь ХХК-аас үнийн санал, бүтээгдэхүүний танилцуулгыг авсан. Дээврийн ажлыг 253 880 000 төгрөгөөр хийлгэх төсөв гарсан бөгөөд төлбөрийг хуваах өгөх нөхцөлтэй байгаа нь бидэнд боломж юм.



Захиалагч: "Ган хийц" ХК — Гүйцэтгэгч, Нийлүүлэгч: "Ондилт" ХХК

"ОХУ"-н ТехноНИКОЛЬ корпорацийн Полимер Мембран LOGICROOF V-RP 1.5мм материал, туслах материалын түүвэр, дээврийн ажил гүйцэтгэлийн үнийн санал.
Дээврийн цэвэр хэмжээ 5590 м.кв — 2018.11.29

| Д/д | Материалын нэрс | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ /төг/ | | Нийт үнэ /төг/ | | Бүгд үнэ /төг/ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Материал | Ажлын хөлс | Материал | Ажлын хөлс | | |
| 1 | Гадаргуй бэлтгэх | м.кв | 5,590 | | 1,000 | - | 5,590,000 | 5,590,000 | Гадаргуй цэвэрлэх, босоо агааржуулалтын хоолой тайрах гэх мэт |
| 2 | **Мембран LOGICROOF V-RP 1.5мм** | м.кв | 6,888 | 20,000 | 9,800 | 137,760,000 | 67,502,400 | 205,262,400 | Үндсэн дээвэр болон парапедны ус тусгаарлах материал |
| 3 | Мембран LOGICROOF S-RT 1.5мм | м.кв | 40 | 20,000 | | 800,000 | - | 800,000 | Парапетны булан, ус зайлуулах хэсэгт хучигтэх гагнах |
| 4 | **Геотекстиль 150 гр/кв.м** | м.кв | 6,200 | 2,000 | - | 12,400,000 | - | 12,400,000 | Хар цаасаас үүсэх урвал, механик гэмтлээс хамгаалах үе |
| 5 | ПВХ төмөр 1*2м | м.кв | 88 | 70,000 | | 6,160,000 | - | 6,160,000 | Полимер Мембраныг Парапетны гадна ирмэг, дээд буланд бэхлэх |
| 7 | Рейк төмөр /3м/ доод | м | 754 | 4,000 | - | 3,016,000 | - | 3,016,000 | Парапетны доод талд Полимер Мембран бэхлэх |
| 8 | Полиуритан герметик 600 мл | ш | 64 | 20,000 | - | 1,280,000 | - | 1,280,000 | Парапет, ПВХ төмрийн хаьцах хэсгийг битүүмжлэх |
| 9 | Шингэн ПВХ | ш | 6 | 70,000 | - | 420,000 | - | 420,000 | Ус зайлуулах Воронк хэсэгт нэмэлтээр битүүмжлэл хийх |
| 10 | Тэлэгч шуруп 8*80мм | ш | 22,500 | 180 | - | 4,050,000 | - | 4,050,000 | Шайба, рейк төмөр, ПВХ төмөр тогтоох |
| 11 | Бетон шуруп 6.3*80мм | ш | 4,200 | 300 | | 1,260,000 | - | 1,260,000 | Тэлэгч шуруп барихгүй хэсэгт тусгай зориулалт бүхий бетоны шуруп ашиглана |
| 12 | Ам дарагч Шайба 50мм | ш | 13,980 | 180 | - | 2,516,400 | - | 2,516,400 | Мембраныг Үндсэн дээвэрт тогтоохад шуруфны хамт ашиглагдана |
| 13 | Ам дарагч, далдлагч Шайба 50*80мм | ш | 4,200 | 480 | - | 2,016,000 | - | 2,016,000 | Бетоны шуруфны хамт мембраны бэхэлгээнд ашиглагдана. |
| 14 | Аэратор 75*240мм | ш | 18 | 30,000 | - | 540,000 | - | 540,000 | Дээврийн чийг гадагшлуулагч амьсгалагч |
| 15 | Аэратор 75*340мм | ш | 18 | 42,000 | - | 756,000 | - | 756,000 | Дулаалгын үед хуримтлагдсан чийгийг гадагшлуулах амьсгалуулагч |
| 16 | Тоосго | ш | 5,460 | 300 | - | 1,638,000 | - | 1,638,000 | Барилгын 4 тал Парапеданд 2 үе тоосго өрөх |
| 17 | Парапед өнгөлөх, шавардлага | дүн | 328 | 11,400 | 4,500 | 3,739,200 | 1,476,000 | 5,215,200 | Тоосго өрөх, шавардлага хийх |
| 18 | Материал дээвэрт гаргах кран | өдөр | 2 | 400,000 | | 800,000 | - | 800,000 | ус тусгаарлах материал дээвэрт гаргах |
| 19 | Материалын тээвэр | рэс | 2 | 80,000 | | 160,000 | - | 160,000 | Нийт материалын тээвэр |
| 20 | Тухайн обьектын нийт дүн: | | | | | **179,311,600** | **74,568,400** | **253,880,000** | **НӨАТ орсон** |

**Полимер Мембран LOGICROOF V-RP материалын эдэлгээ 50 жил**
Полимер Мембран LOGICROOF V-RP нь гал дэмжихгүй
**Гүйцэтгэлийн баталгаа 10 жил**
/-50/ градусаас /+60/ градуст тэсвэртэй
**Гүйцэтгэх хугацаа 40-45 хоног**
Ажиллах хүчний тоо 10-15 хүн

Тооцоог гаргасан: М.Угтанменх






# 2019 ОНЫ ЗАХИАЛГАТ АЖИЛ

- 2019 онд Төв аймгийн Сэргэлэн суманд баригдах Их майдар төслийн хүрээнд Их майдар сангийн захиалгаар 585 285 290 төгрөгийн төмөр хийцийн үйлдвэрлэлт угсралтын ажил хийхээр гэрээ байгуулсан.







Анхаарал хандуулсанд баярлалаа

2019 оны 04-р сарын 23